Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3
1.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО ..... 3
1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ ..... 3
1.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АШИГЛАЛТ ..... 4
1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ ..... 10
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 12
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 17
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 17
5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 18
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 20
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..... 22
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 24
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ биелэлт ..... 25

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ............ 12
Хүснэгт 2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөУрьдчилан............ 18
Хүснэгт 3. Хог хаягдлын биелэлт ............ 20
Хүснэгт 4. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр............ 22

## Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил............ 3
Зураг 2. Төслийн талбайн харагдах орчин............ 4
Зураг 3. Оффисын барилга урдаасаа............ 4
Зураг 4. Оффисын аюулгүй ажиллагааны самбар, санал хүсэлтийн хайрцаг............ 5
Зураг 5. Оффисын ил тод байдлын самбар ............ 5
Зураг 6. Ажилчдын цайны газар............ 5
Зураг 7. Оффисын ариун цэврийн өрөө............ 6
Зураг 8. Ажилчдын амрах өрөө............ 6
Зураг 9. Ажилчдын амрах байр............ 6
Зураг 10. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар ............ 7
Зураг 11. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар ............ 7
Зураг 12. Ажилчдын амрах өрөө............ 7
Зураг 13. Ажилчдын байрны ариун цэврийн өрөө ............ 8
Зураг 14. Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч............ 8
Зураг 15. Пүүний хэсгийн тэмдэг тэмдэглэгээ............ 8
Зураг 16. Пүү хажуугаас харагдах байдал............ 9
Зураг 17. Авто зогсоолын харагдах байдал............ 9
Зураг 18. Ачиж буулгах талбайн харагдах байдал (2024 он)............ 9
Зураг 19. Авто засварын байр ............ 10
Зураг 20. Уурын зуухны байр............ 10
Зураг 21. Мод тарьж буй байдал ............ 17
Зураг 22. Хөрсний дээж авч буй зураг ............ 23
Зураг 23. Агаарын дээж авах үеийн зураг............ 23
Зураг 24. Орчны цэвэрлэгээ хийж буй байдал............ 24

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** Гаалийн хяналтын талбай

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** “Чинзасагт” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 2911003070

Регистрийн дугаар: 4491025

**Хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Сүмбэр таур, 13-1 тоот

Утас: 91692034

### 1.1. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Чинзасагт ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд өөрийн эзэмшлийн 20 га талбайн 10 га талбайд Гаалийн баталгаат агуулах, 10 га талбайд Гаалийн хяналтын талбай байгуулж, өөрийн Гаалийн хяналтын бүсээр дамжуулан улс хоорондын ачаа тээвэрлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.

### 1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 646 км, Дорноговь аймгаас 190 км, Замын-Үүд сумын төвөөс 6 км-т УБТЗ Логистикийн баруун хойд талд байрлана.




Зураг 1. Төслийн байршил



Зураг 2. Төслийн талбайн харагдах орчин

## 1.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АШИГЛАЛТ

Төслийн талбай нь ачиж буулгах талбай, пүү, авто машины зогсоол болон оффис, ажилчдын амрах байраас бүрдэнэ.

***Оффис.*** Оффисын байр нь оффисын хэсэг, ажилчдын амрах хэсэгтэй. Оффисын хэсэгт Гаалийн байцаагчийн өрөө, Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний өрөө, Чинзасагт ХХК-н оффисын өрөө 00-н өрөөнөөс бүрдэнэ. Ажилтны амралтын хэсэг нь гал тогоо, 6 амралтын өрөө, 00-н өрөөтэй.



Зураг 3. Оффисын барилга урдаасаа

Оффисын аюулгүй ажиллагааны самбар болон ил тод байдлын самбар




Зураг 4. Оффисын аюулгүй ажиллагааны самбар, санал хүсэлтийн хайрцаг




Зураг 5. Оффисын ил тод байдлын самбар

Ажилчдын цайны газар



Зураг 6. Ажилчдын цайны газар

### Оффисын ариун цэврийн өрөө

Оффисын хэсэгт 1 ариун цэврийн өрөө байх ба 4 суултуур 2 тосгууртай. Нойл тус бүрт “Ариун цэврийн өрөөний соёл”-ын мэдээллийн хуудас, ариутгах иж бүрдэлтэй.



Зураг 7. Оффисын ариун цэврийн өрөө

### Ажилчдын амрах өрөө

Ажилчдын амрах хувцас солих 7 өрөөтэй. Тус бүр 2 болон 3 ортой.



Зураг 8. **Ажилчдын амрах өрөө**

### Ажилчдын амрах байр



Зураг 9. Ажилчдын амрах байр

## Ажилчдын амрах байрны аюулгүй ажиллагааны самбар




Зураг 10. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар

## Ажилчдын байрны галын ослын схем




Зураг 11. Ажилчдын байрны аюулгүй ажиллагааны самбар

## Ажилчдын амрах өрөө

Ажилчдын хувцас солих, амрах нийт 13 өрөө байна. Өрөө бүрд 3 ширхэг нэг хүний ортой.




Зураг 12. Ажилчдын амрах өрөө

## Оффисын ариун цэврийн өрөө

Ажилчдын амрах байранд ариун цэврийн өрөө байх ба нийт 4 ариун цэврийн суултуууртай нойлтой. Нойл тус бүрд “Ариун цэврийн өрөөний соёл”-ын мэдээллийн хуудас байна. Мөн нойл тус бүрд ариутгах иж бүрдэлтэй.




Зураг 13. Ажилчдын байрны ариун цэврийн өрөө

## Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч




Зураг 14. Оффисын гадна байрлах цуглах цэг болон саравч

***Пүү.*** Төслийн талбай орох хаалганы урд хэсэгт ухаалаг гарц суулгасан пүү байрласан байна.




Зураг 15. Пүүний хэсгийн тэмдэг тэмдэглэгээ



Зураг 16. Пүү хажуугаас харагдах байдал

***Авто машины зогсоол.*** 2024 онд 10 га талбайд 1500 машин хайрга дэвсэж авто зогсоол хийсэн.



Зураг 17. Авто зогсоолын харагдах байдал

Ачиж буулгах талбай.



Зураг 18. Ачиж буулгах талбайн харагдах байдал (2024 он)

Авто засвар

2024 онд 200 мкв авто засварын байрыг ашиглалтад оруулсан. Ингэснээр ил задгай тос масло асгарч байгаль орчин бохирдуулахаас урьдчилан сэргийлэх боломжтой болсон. Авто засварын байр нь засвар хийх хэсэг болон сэлбэг, тос масло агуулах агуулахын өрөөтэй.





Зураг 19. Авто засварын байр

## 1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

**Цахилгаан хангамж:** Улаанбаатар төмөр замын эрчим хүчний төвийн шугамаас дэд станцаар дамжуулан холболт хийж цахилгаан эрчим хүчээр хангагдана. Чинзасагт ХХК нь Замын-Үүд ТП-18 дэд станцаас гарсан “Шугам зам” фидерийн 10 кВ хүчдэлийн шугамын тулгуур №70-аас салбарласан салбар шугамын төгсгөл дэх КТПН-30/10/0.4 кВ хүчдэлийн дэд станцыг 100 кВА чадлын болгон хүчин чадлыг нэмэгдүүлсэн 10/0.4 кВ суурилагдсан хүчдэлтэй цахилгаан эрчим хүчээр хангах Эрчим хүч, Ус хангамжийн төвийн даргын 14/2022 тоот техникийн нөхцөлийг гаргуулсан байна.

**Усан хангамж:** Зөөврийн усаар ахуйн болон ундны усыг хангаж байна.

**Халаалт:** 2024 онд 2500 мкв халаах хүчин чадалтай уурын зуухыг ашиглалтад оруулсан.





Зураг 20. Уурын зуухны байр

**Зам тээврийн сүлжээ:**

*Авто зам:* Төслийн талбайн баруун талаар 0.15 км зайд УБ- Замын-Үүд чиглэлийн автозам дайран өнгөрдөг.

*Төмөр зам:* Төслийн талбайн зүүн талаар УБ-Замын-Үүд чиглэлийн төмөр зам дайран өнгөрдөг. Төлөвлөж буй Гаалийн баталгаат агуулахад чингэлэгт ачаа ачиж, буулгах зорилгоор Улаанбаатар төмөр замын Логистикийн үндсэн төмөр замаас 3.18 км туслах төмөр замыг салаалж төслийн талбай хүртэл байна.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|---|
| 1 | Ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулж, засвар үйлчилгээг тогтмол хийх | Техник хэрэгслийг өдөр бүрийн өглөө талбайд гарахад үзлэгт оруулж шалгадаг болно.   | |

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|---|
| 2 | Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайг тойруулан 8-12 м өндөртэй салхинаас хамгаалах торон хашааны эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд тухай бүрд засварлах | Эвдрэл гарах бүрд засварлаж ажилсан. |  |

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт | Баримтжуулсан фото зураг |
| --- | --- | --- | --- |
| 3 | Тоосжилтыг багасгах үүднээс засмал замаас талбай хүртэлх 1.0 км урт 10 метр өргөн замыг сайжруулан засаж хайрга дэвсэнэ. | Сайжруулан засаж хайрга дэвсэв.   | |

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|---|
| 4 | Тоосжилт ихтэй үед усалгаа хийх | **Хуурайшилттай, тоосжилттой үед тогтмол усалгаа хийсэн.**   |    |
| 5 | ОХШХ-т тусгасан агаарын чанарын шинжилгээг хийлгэх | ОХШХ-ийн хэсэгт тусгасан. | |
| 6 | - Газрыг үр өгөөжтэй зүй зохистой ашиглах<br>- Төлөвлөгдсөнөөс өөр талбайд нүүрсний овоолго үүсгэхгүй байх, талбайг зохион байгуулалттай ашиглах<br>- Машин, техник болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах, |    |    |

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|---|
| 7 | Ажиллагсдын байрлах суурины эргэн тойронд машин механизмын хөдөлгөөний хязгаарласан гортиг татаж, зориулалтын талбай гарган орчны ургамлын талхагдлыг бууруулах арга хэмжээ авах |   |  |
| 8 | ШТМ асгарах, алдагдах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд байрлуулах | 200 мкв авто засварын байрыг ашиглалтад оруулсан. Ингэснээр ил задгай тос масло асгарч байгаль орчин бохирдуулахаас урьдчилан сэргийлэх боломжтой болсон. Авто засварын байр нь засвар хийх хэсэг болон сэлбэг, тос масло агуулах агуулахын өрөөтэй.    | |

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэгч Чинзасагт ХХК нь 20 га талбайн 10 хувь буюу 2 га талбайд мод тарих төлөвлөгөөний дагуу 2025 оны 10 дугаар сарын 5-нд 100 ширхэг улиас, 100 ширхэг улаан сухай модыг ажилчдын амрах байр, талбайн урд болон баруун талаар тарьсан. Борхойн Баянбүрд" ОНӨААТҮГ-аас суулгацуудыг худалдан авсан.



Зураг 21. Мод тарьж буй байдал

## 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих орчинд сум суурин газар олон жил үйл ажиллагаа явуулсан, тэмдэглэгдэж бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл сумын төвийн тухайн орчинд байхгүй.

## 5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, тайлбар | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|
| Ажлын талбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах<br>Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах: Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур тэмдэг тавьсан байх хэрэгтэй.<br>Гал гарсан тохиолдолд:<br>– Галаас яаралтай гарах<br>– Гал түймрийн үед барилга байгууламж бүрд тохирох заавры ашиглах | 20 га талбайд 20 ширхэг иж бүрэн галын хайрцгийг байршуулсан. Мөн оффист 10ш, ажилчдын амрах байранд 6 ширхэг галын хорыг байршуулсан. Бүх галын хор нь хэвийн ажиллагаатай байна.<br> <br>    | |

| сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, тайлбар | Баримтжуулсан фото зураг |
|---|---|---|
| Хүний эрүүл мэнд муудахад харьяа сумын эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэх арга хэмжээг авна. | Үйлчлүүлэгч болон ажилчдын эрүүл мэнд муудах тохиолдолд харьяа сумын эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэж өгөх эсвэл яаралтай тусламж буюу 103 дуудаж арга хэмжээ авдаг. |  |
| Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах | Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангаж ажилласан. | |
| Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээний тухай бодлогыг боловсруулж, мөрдөж ажиллах, нэг буюу түүнээс олон автомашин хамарсан осол гарсан тохиолдолд компанийн даатгалын журмыг мөрдөнө. Ослын улмаас хүн бэртэж гэмтэх буюу нас барсан тохиолдолд урьд нь тогтоосон эмнэлгийн түргэн тусламжийн журмыг мөрдөнө. Гал түймэр гарвал галын журмыг мөрдөнө. | Аюулгүй байдал аваар ослын тэмдэг тэмдэглэгээг байршуулж аюулгүй ажиллагааны зөвлөмж зааварчилгааг тогтмол өгдөг. Сургалт, ухуулга, ХАБЭА-н сургалтыг тогтмол зохион байгуулж байна. 2025 онд осол аваар тохиолдоогүй болно. |  |

## 6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Хог хаягдлын биелэлт

| *Хог хаягдлын ангилал* | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт, тайлбар |
|---|---|---|
| *Ахуйн* | Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх<br>Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хийцлэлтэй зориулалтын цэг байгуулах |     |
| | Хогийн цэг, бохирын цооног болон ажилчдын байр зэргийг ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж стандартын шаардлага хангасан зориулалтын бодис хэрэглэн устгал, ариутгал хийж байх |   |
| | Шингэн хаягдал хаях цооног дах бохирдлын хэмжээг хянах, бохир усны танк 70-80 % дүүрсэн үед тогтмол соруулах |   |

| | | |
|---|---|---|
| *Ахуйн* | Хогийг зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх | Ахуйн хог хаягдлыг Замын-Үүд сумын НААУ ОНӨ-тай байгуулсан хог хаягдал зайлуулах гэрээний дагуу хог хаягдлыг 14 хоногт 1 удаа тээвэрлүүлдэг.<br>Оффисын байр болон, ажилчдын амрах байрны гадаа хог ангилан ялгах хогийн савыг байршуулсан.<br>  |
| ***Аюултай хог хаягдал*** | Аюултай хог хаягдлыг түр хадгалах хогийн сав байгуулах |  |

## 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр

| № | Хяналт шинжилгээ явуулсан үзүүлэлт | Шинжилгээ хийлгэсэн лаборатори | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хөрсний бохирдлын үзүүлэлт | “Нарт ШУУН” лаборатори | 2025.10.27-нд дээж авсан, хариу гараагүй байна_ |
| 2 | Агаарын чанарын ($NO_2$, $SO_2$, CO, $PM_{2.5}$, $PM_{10}$) шинжилгээ | Дорноговь аймгийн УЦУОШГ-ын лаборатори | 10 сарын 29-нд хэмжилт хийлгэсэн. Стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй. |















Зураг 22. Хөрсний дээж авч буй зураг



Зураг 23. Агаарын дээж авах үеийн зураг

## 8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|
| 1. | Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох | Мөрдөн ажилласан |
| 2. | Дотоодод боловсруулсан дүрэм журмуудыг мөрдүүлэх, хяналт тавих | Мөрдөн ажилласан |
| 3. | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх; | Талбайн эргэн тойрон 50 м радиуст сар бүр цэвэрлэгээг хийж ажилласан. |
| 4. | Байгаль орчны аудитыг эрх бухий мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Хийгдээгүй |
| 5. | Энгийн хог хаягдлын гэрээ | Замын-Үүд сумын НААҮ ОНӨ-тай хог хаягдал зайлуулах гэрээтэй. |
| 6. | Усны гэрээ | "Борхойн Баянбүрд" ОНӨААТҮГ-тай 2025 оны 04 сарын 01-нд байгуулсан хэрэглээний ус худалдан авах гэрээтэй. |
| 7. | Бохир соруулах гэрээ | "Замын Үүдийн дулааны станц" ТӨҮГ-тай 2025 оны 01 сарын 01-нд байгуулсан гэрээтэй. |



Зураг 24. Орчны цэвэрлэгээ хийж буй байдал

## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|
| 1. | Дорноговь аймгийн байгаль орчны газарт биелэлтийн тайлан хүргүүлэх | 2025 оны 11 сарын 1-ний дотор биелэлтийн тайланг хүргүүлэв. |

# ХАВСРАЛТУУД

2025 оны батлагдсан БОМТ
БО-ыг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны төлбөр тушаасан баримт
Агаарын шинжилгээний хариу
Улсын бүртгэлийн гэрчилгээ
Газрын материал
Гаалийн хяналтын талбайн зөвшөөрөл
Усны гэрээ
Энгийн хог хаягдлын гэрээ
Бохир соруулах гэрээ
Цахилгааны гэрээ
Модны суулгац худалдан авсан гэрээ

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА
Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ЧИНЗАСАГТ" ХХК ЗАХИРАЛ
Э. БАТМӨНХ

"ЧИНЗАСАГТ" ХХК НИЙ ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМАНД БАЙРЛАНА. ЧИНЗАСАГТ ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХ БОЛОН ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4491025

ХЯНАСАН:
МЭРГЭЖИЛТЭН /ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨЛ ХАРИУЦСАН/
Л. ОРГИЛ

БОЛОВСРУУЛСАН:
"ЧИНЗАСАГТ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН
Б. САЙНЗАЯА

2025 ОН

ХААН БАНК

Огноо/Date: 2025-07-02 15:36:44

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 27144683

Гүйлгээний дугаар /Poid: 1192086995

Системийн огноо/System Date: 2025-07-02 15:36:25

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
| | 5212162217 | ЧИНЗАСАГТ | 2,267,000.00 MNT | 1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No | Банкны нэр/Bank Name | | |
| | MOFUMNUB | ТӨРИЙН САН | 2,267,000.00 MNT | 1.00 |
| | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number | Нэр/Name | | |
| | MN560090 000061455403 | | | |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ЧИНЗАСАГТ ХХК 4491025 БАЙГАЛЬ ОРЧН

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2025/163
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Чинзасагт" ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Хандсүрэн /Лабораторийн инженер/
Сорьцын төрөл, тоо : $SO_2$-2, $NO_2$-2, Нийт тоос-2
Хүлээн авсан огноо : 2024.10.29
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Замын-Үүд сум
Шинжилсэн огноо : 2025.10.30
Хуудасны тоо : 1

**Үр дүн**

| № | Дээж авсан цэгийн нэр | Хүхэрлэг хий, $SO_2$ мг/м$^3$ | Азотын давхар исэл, $NO_2$ мг/м$^3$ | Нийт тоосны агууламж мг/м$^3$ |
|---|---|---|---|---|
| 1 | Нурмаг ачилтын талбай<br>N 43°45'39.1"<br>E 111°50'51.2" | 0.010 | 0.017 | 0.193 |
| 2 | Импортын талбай<br>N 43°45'32.3"<br>E 111°50'40.5" | 0.006 | 0.006 | 0.098 |
| **ЗДХ** | **MNS4585:2025** | **0.450** | **0.200** | **0.500** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер Ч. Түмэннаст
Хянасан: Лабораторийн технологич инженер О. Бат-Оюун
Баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга Ш.Амарбилэг

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000030718

2012.02.20
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

2911003070
/ Улсын бүртгэлийн дугаар /

4491025
/ Регистрийн дугаар /

Чинзасагт Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2012.02.20 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он,сар,өдөр / |

| 511001 | Худалдааны зуучлал |
|---|---|
| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| | |
|---|---|
| / код / | / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 1 | 1,499.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Налайх, 2-р хороо, Даваажавын гудамж, Сургуулийн-1 - 1 тоот, утас1:99097520, утас2: , факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

УХА0463

## Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| Худалдаа хөгжлийн банк | Төгрөгийн | 463003586 | Билэгсүх |
| Худалдаа хөгжлийн банк | Валютын | 463003587 | Билэгсүх |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 2 | 5221 Төмөр замын шугамын доод бүтэц угсрах, төмөр замын хоолой угсрах 2015.08.16 хүртэл эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2012.12.24 | Б.Оюун-Эрдэнэ |
| 3 | Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, гэгээнтэн, 101, 20 Утас1: 99111976, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.07.06 | Г.Санжаа |
| 4 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.07.06 | Г.Санжаа |
| 5 | Харцэхэр овогтой Энхжаргал-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.07.06 | Г.Санжаа |
| 6 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2021.07.06 | Г.Санжаа |
| 7 | 5221 Төмөр замын шугамын доод бүтэц угсрах, төмөр замын хоолой угсрах 2015.08.16 хүртэл үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>4610 Худалдааны зуучлал үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>49230 Авто машинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.07.06 | Г.Санжаа |
| 11 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2023.12.04 | Б.Нарантуяа |
| 12 | Эцсийн өмчлөгч өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2023.12.04 | Б.Нарантуяа |
| 13 | Эрдэнэцогт овогтой Батмөнх-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2024.06.14 | Ж.Амарсайхан |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

МОНГОЛ УЛС

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000185638**

Чинзасагт ХХК 4491025
*(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Аймгийн Засаг даргын захирамж 20 23 оны 05 сарын 03 өдрийн А/288 тоот
*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Дорноговь Замын-Үүд 3-р баг, Жаргалант
*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Борхойн тал 4 хаягт
*(гудамжны нэр)* *(хашааны дугаар)*

байрлах, нэгж талбарын 4401010313 дугаар бүхий 200000 м.кв газрыг

Терминал (ачиж, буулгах талбай) зориулалтаар

9 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-0714000204

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2023-05-03**

# Дорноговь аймгийн Замын-Үүд сум

Нэгж талбарын дугаар: 4401010313 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 4491025 Хуулийн этгээдийн нэр: Чинзасагт

**ХАЯГ:** Аймаг/Хот: Дорноговь Сум/Дүүрэг: Замын-Үүд Баг/Хороо: 3-р баг, Жаргалант Кадастрын муж: 0010
ШИНЭ: Гудамж: Борхойн тал Тоот: 4 ХУУЧИН: ГудамжТөмөр замын баруун талд Тоот: 0




Зургийн масштаб = 1:5207 (1 сантиметрт 52.07 метр багтана) Хэвлэсэн огноо: 2023-03-31

Орчны тойм



Масштаб = 1: 866686

Координатын систем:

WGS84/UTM 49N

EPSG: 32649

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 567748.34 | 4845402.59 | 640.30 |
| 2 | 568200.65 | 4845855.38 | 312.67 |
| 3 | 568421.74 | 4845634.52 | 640.30 |
| 4 | 567969.43 | 4845181.74 | 312.67 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|

Талбайн хэмжээ: 200000 квадрат метр

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 17 өдөр Дугаар А/323 Улаанбаатар хот

“Чинзасагт” гаалийн хяналтын
бүс тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсэг, $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.17 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын 2022 оны А/339 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 04/05 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Чинзасагт” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 3 дугаар багт байрлах 10 га талбайг нүүрс ачиж, буулгах, шилжүүлэн ачих зориулалттай гаалийн хяналтын бүсээр гурван жилийн хугацаатай тогтоосугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ын 4 дүгээр хавсралтад “Чинзасагт-303017” гэж нэмсүгэй.

3.Чинзасагт ХХК-тай гэрээ байгуулан, Гаалийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Замын-Үүд дэх гаалийн газар /О.Цэенрэгзэн/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Даваасүрэн/-т даалгасугай.

ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 1956

Хэрэглээний Ус Худалдан авах Гэрээ

№2025040701

"Борхойн Баянбүрд" ОНӨААТҮГ-ийг (РД: 8275092, цаашид "худалдагч" гэнэ) төлөөлж Ерөнхий захирал Г.Энхбат , "Чинзасагт" ХХК-ийг (РД: 4491025, цаашид "худалдан авагч" гэнэ төлөөлж Ерөнхий захирал Э.Батмөнх нар харилцан тохиролцсоны үндсэн дээр сар бүр Хэрэглээний усыг нийлүүлэхээр энэхүү гэрээг 2025 оны 4 сарын 01-ий өдрөөс 2025 оны 12 сарын 31-ыг дуустал 9 сарын хугацаатай байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хэрэглээний ус нийлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Худалдагч талын эрх, үүрэг, хариуцлага

2.1 Сар бүр хэрэглээний цэвэр усаар тасралтгүй хангана.

2.2 Нийлүүлэх ус нь эрүүл ахуй-чанарын шаардлагад нийцсэн байх.

2.3 Төлбөрийн баримтын системд зарлагадсан усны тооцоог баримтжуулах

ГУРАВ. Худалдан авагч талын эрх, үүрэг, хариуцлага

3.1 Гэрээний дагуу сар бүр хэрэглээний усыг худалдан авна.

3.2 Усыг агуулах болон тээвэрлэх зардлыг бүрэн хариуцна.

3.3 Худалдан авсан усны төлбөрийг бүрэн төлнө.

ДӨРӨВ. Төлбөр тооцоо

4.1 Худалдагч тал сар бүрийн 25-нд нийлүүлсэн усны төлбөр тооцоог И-баримтаар нэхэмжлэнэ.

4.2 Худалдан авагч тал Нэхэмжлэх ирүүлснээс 5 хоногийн дотор Худалдагчийн

<u>ХААН банк 537 462 6707</u> тоот дансанд төлбөрийг бүрэн барагдуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| "Борхойн Баянбүрд" ОНӨААТҮГ-ийг төлөөлж: | "Чинзасагт" ХХК-ийг төлөөлж: |
| ..................................... | ..................................... |
| Гүйцэтгэх Захирал: | Гүйцэтгэх Захирал: |
| /Г.Энхбат/ | /Б.Батмөнх/ |
| Утас: 96626298 | Утас: 91692034 |

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК

**“Хог хаягдлын” тухай хуулийг хэрэгжүүлэх айл өрхийн гэрээ**

Гэрээний дугаар: Ч.......................
Байгууллагын нэр : Чинзасагт ХХК

Замын-Үүд
2025 он

**Батлав: Замын-ҮҮДНААУ ОНӨ ХХК**
**Захирал: . Ө.Нарантуяа**

**“Хог хаягдлын” тухай хуулийг хэрэгжүүлэх гэрээ**

**2025 он 01 сар 02 өдөр Борхойн тал**

Энэхүү гэрээний зорилго нь Монгол улсын “Хог хаягдлын тухай” хуулийг хэрэгжүүлэхэд оршино.

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, экспортлох болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**

2.1..Засгийн газраас тогтоосон аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох

2,2. Сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг устгах цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох

**9.1.Хог хаягдлын талаар иргэн дараах эрх эдлэж, үүрэг хүлээнэ:**

9.1.1.энэ хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;

9.1.2.үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх;

9.1.3.зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх;

9.1.4.үүсгэсэн хог хаягдлаа ангилан ялгаж, тогтоосон цэгт хаях;

9.1.5.оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох;

9.1.6.ил задгай хог хаягдал шатаахгүй байх;

9.1.7.аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгуулах;

9.1.8.хуульд заасан бусад эрх, үүрэг

**Тав: Хариуцлага**

5.1 Хог хаягдлын тухай хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь “ Хог хаягдлын тухай” хуулийн 23 дугаар зүйл заагдсан доорхи хариуцлагыг хүлээнэ.

23.1.**Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараах хариуцлага хүлээлгэнэ:**

23.1.1.**зориулалтын бус газар хог хаягдал хаясан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,** аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

23.1.7.**энэ хуулийн 9.1.6, 9.2.9-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,** аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох.

**<u>Зургаа: Бусад</u>**

6.1 **Иргэн өөрийн эзэмшил, өмчлөлийн барилга, объект, хашаа .барих, буулгах, засварлах, уурын зуухны үнс, хуралдсан элс зэрэг хэмжээ ихтэй, ачихад хүндрэлтэй хог хаягдал гаргах тохиолдолд урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлсний үндсэн дээр хог хаягдлыг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх устгах эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ.**

6.2 **Тухайн иргэн 6,1-д заасан үйлчилгээнд хамруулахад Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн №26 тоот тогтоолын дагуу хог хаягдал гаргагч эх үүсвэрүүд 1м³ хог хаягдлыг 10000 төгрөг, дуудлагын 10000 төгрөгийг нэмж тооцсон тарифаар дуудлагын үйлчилгээг үзүүлнэ.**

6.3 Энэхүү гэрээг 202.5. оны ..01.. сарын ..06.... ны өдрөөс 202.6 оны 01.....-р сарын 01..... өдрийг хүртэл 1 жил...... хугацаатай байгуулав.

6.4 Энэхүү гэрээг 202.5 оны ..01.. сарын 06..өдөр 2% үйлдэж тээвэрлэгч, үйлчлүүлэгч талууд тус бүр нэг хувийг хадгална.

6.5 Иргэн ......Чинзасагт ХХК...... нь ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 09/53 дугаар тогтоолын дагуу хог хаягдлын үйлчилгээний нэг сарын хураамж болох ....84,000.... төгрөгийг **Замын–Үүд сумын Татварын албаны Төрийн сан банкин дахь 061400995 тоот дансанд тухайн** сар бүрийн –25 ны дотор шилжүүлнэ.
**Дуудлагын утас: 80118432**

| д/Д | НО | О | Хог тээврийн | Төлсөн | Хүлээн | Төлбөр | Шалгасан |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | хураамж / төг/ | хураамж | дүн | авсан хүний гарын үсэг | төлсөн иргэний гарын үсэг | нягтлан бодогч |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 3000 | | | | | |
| 2 | | 3000 | | | | | |
| 3 | | 3000 | | | | | |
| 4 | | 3000 | | | | | |
| 5 | | 3000 | | | | | |
| 6 | | 3000 | | | | | |
| 7 | | 3000 | | | | | |
| 8 | | 3000 | | | | | |
| 9 | | 3000 | | | | | |
| 10 | | 3000 | | | | | |
| 11 | | 3000 | | | | | |
| 12 | | 3000 | | | | | |
| Ã¯н | | 36000 | | | | | |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Тээвэрлэгч байгууллагыг төлөөлж: Иргэн:

................................................ ................................................

/ албан тушаал /

................................................ ................................................

/ овог, нэр гарын үсэг, тамга/ / овог, нэр гарын үсэг, тамга/

ЧИНЗАСАГТ ХХК
ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС
4491025 ∘ ГТА1875

Чинзасагт ХХК

## Хог хаягдлын хураамжийн тооцоо 2025 он

| д/Д | Огноо | Хог тээврийн | | Төлсөн дүн | Хүлээн авсан хүний гарын үсэг | Төлбөр төлсөн иргэний гарын үсэг | Шалгасан нягтлан бодогч |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хураамж / төг/ | хураамж | | | | |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |
| 9 | | | | | | | |
| 10 | | | | | | | |
| 11 | | | | | | | |
| 12 | | | | | | | |
| Ä¯н | | | | | | | |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

Тээвэрлэгч байгууллагыг төлөөлж:

.................................................

/ албан тушаал /

.................................................

/ овог, нэр гарын үсэг, тамга/

Иргэн:

.................................................

.................................................

/ овог, нэр гарын үсэг, тамга /

ЧИНЗАСАГТ ХХК
ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС
4491025 ○ ГТА1875

**БАТЛАВ:**
**"ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨҮГ-ЫН**
**ЗАХИРАЛ О.ТӨМӨРХУЯГ**

**АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ, ХЭРЭГЦЭЭНИЙ ХАЛУУН ХҮЙТЭН УСААР ХАНГАХ, БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2025 оны дугаар 01 сарын 01-ний өдөр №.... Борхойн тал

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэхүү гэрээг хангагч талаас "Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ-ыг төлөөлж Захирал О.Төмөрхуяг /цаашид "Хангагч" гэх/, хэрэглэгчийг төлөөлж дараах мэдээлэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүн худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа хууль ёсны өмчлөгч болон өмчлөгчөөс албан ёсоор итгэмжлэгдсэн төлөөлөгч Захирал албан тушаалтай Чинзасагт ХХК /цаашид "Хэрэглэгч" гэх/
Хэрэглэгчийн хаяг: Замын-Үүд хот 3-р баг
Хэрэглэгчийн нэр: Чинзасагт ХХК
Хэрэглэгчийн дугаар: 34003186 Регистрийн дугаар: 4491025
ҮХЭХ гэрчилгээний №: .................... Дулааны эзлэхүүн: ....................
/цаашид хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Орон сууцны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн 20.... оны .... дугаар сарын ....-ний өдрөөс 3 /гурав/ жилийн хугацаатай дор дурдсан нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Ус, дулаан хангамжийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун хүйтэн усыг зүй зохистой, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах үүднээс хангагч ба хэрэглэгч нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

2.1. Гэрээ байгуулагч хоёр тал Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудад заасан эрх үүргийг хэрэгжүүлэхэд гэрээний гол зорилго оршино.

2.2. Энэхүү гэрээ нь хангагчаас хэрэглэгч / аж ахуйн нэгж, байгууллага/-ийг халуун хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах, инженерийн шугам сүлжээг хэвийн найдвартай ажиллуулах, засвар үйлчилгээг шуурхай чанартай хийж гүйцэтгэх.

2.3 Энэхүү гэрээг үл хөдлөх хөрөнгө, эзэмшигчтэй байгуулах тохиолдолд хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Харин үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугчтай гэрээ байгуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, өмчлөгчөөр давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

2.4 Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө, өмчлөгч, эзэмшигч, хамтран хариуцагч, түрээслэгч, түр оршин суугч нар нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

2.5. Хэрэглэгч хэрэглэсэн ус, дулааны төлбөр тооцоог тухай бүрд нь барагдуулах зэрэг харилцааг зохицуулахад оршино.

1

4.1. Хэрэглэгч нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актууд болон энэхүү гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.2. Хангагч байгууллагын эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, тоолуурын заалт авах болон энэхүү Гэрээний 3.9.3-д заасны дагуу хэрэгцээний халуун, хүйтэн ус хангамжийг хязгаарлаж тоолуурыг битүүмжлэхэд саадгүй оруулна.

4.3. Хэрэглэгч нь инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, бусад өмчлөгч, оршин суугчдын тав тухтай амьдрахад саад болохгүй, барилгын хийц инженерийн шугам сүлжээний элементийг дур мэдэн өөрчлөхгүй байж хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

4.4. Хэрэглэгч нь хэрэгцээний халуун, хүйтэн усны тоолуурын лац ломбонуудын бүрэн бүтэн /Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн болон тухайн салбар нэгжийн ломбо/ байдлыг бүрэн хариуцаж баталгаат хугацаа дуусмагц өөрийн зардлаар дахин баталгаажуулна.

4.5. Хэрэглэгч нь шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу хэвийн ашиглахтай холбогдсон мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх, мөн шалан доор гэмтэл гарах, далд монтажлагдсан болон завсар дундын шугам хоолой цоорох үед далд шугамыг ил гарган мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй ба засварын ажил дууссаны дараа тухайн ажил хийгдсэн газрын нөхөн сэргээлтийг хэрэглэгч хариуцна.

4.6. Хэрэглэгч нь өөрийн өмчлөлийн байраа бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад түрээслүүлсэн бол дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангах гэрээг өөрийн нэр дээр байгуулж төлбөр тооцоог өөрөө хариуцна.

4.7. Хэрэглэгч нь байрныхаа инженерийн байгууламжид гарч буй гэмтлийг хангагчид яаралтай мэдэгдэж засварлуулна.

4.8. Хэрэглэгч нь тоо хэмжээ, чанар, стандартын шаардлага хангаагүй дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн ус нийлүүлсэн тухай бүрд хангагчид мэдэгдэж хэвийн болгохыг шаардах эрхтэй.

4.9. Хэрэглэгч нь барилга байгууламжийг өөр этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэх тохиолдолд хангагчтай байгуулсан гэрээг цуцлах талаарх саналаа ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө хангагч талд мэдэгдэж хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог хийж өр авлагыг барагдуулсан байна.

4.10. Орон сууц худалдан авагч нь өөрийн өмчлөлдөө шилжүүлэхээс өмнө уг орон сууцтай холбоотой төлбөр тооцоо байгаа эсэхийг хангагч байгууллагуудаас магадлах үүрэгтэй ба төлбөр төлөөгүйгээс үүсэх үр дагаврыг өөрөө бүрэн хариуцна.

4.11. Орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээний үнэ тарифыг өөрчилсөн эрхийн актыг үзэж танилцах эрхтэй.

4.12. Орон сууцны дулаан, хэрэгцээний халуун, хүйтэн ус, цэвэр бохир ус болон бусад төлбөрийг сар бүрийн 25-ны дотор төлөх, хэрэв уг хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги тооцно.

4.13. Хэрэглэгч нь ааварын үед хангагч байгууллагад 24 цагийн турш **72001313-1** дугаарт дуудлага өгч ааварыг устгуулна.

4.14. Хэрэглэгч нь өөрийн өмчлөлийн ус дулааны шугам сүлжээ, тоноглолыг солих шинэчлэх тохиолдолд засвар үйлчилгээ хийх засварчныг сонголтоор авч төлбөртэй үйлчлүүлж болно.

4.15. Хэрэглэгч дуудлагаар төлбөрт засвар үйлчилгээ хийлгэхдээ үйлчилгээний хөлсийг засварчинд бэлнээр төлөхгүй бөгөөд баталгаат дардас бүхий баримтад гарын үсэг зурж баталгаажуулан тухайн сарын ашиглалт үйлчилгээний төлбөртэй хамт төлнө.

4.16. Хэрэглэгч Хангагчтай тооцоо хийдэг тоолуурын бүрэн бүтэн байдлыг хариуцах гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэж хангагчийн эрх бүхий ажилтны хийсэн битүүмжлэлийн бүрэн байдлыг хариуцна.

4.17. Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу Түгээх зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.

3

6.1. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3-т заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан дулааны тоолуурын холболтыг шалгаж битүүмжлэн холбогдох журмын дагуу хүлээн авч төлбөр тооцоонд ашиглана.

6.2. Хангагчийн эрх бүхий ажилтан нь тухайн хэрэглэгчийн тоолуурын лац ломбоны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянаж сард 1 удаа тоолуурын тооцооны хуудас дээр параметрийн тэмдэглэгээ хийж хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулна. Энэхүү хуудсыг үндэслэн тухайн сарын төлбөр тооцоог хийнэ.

6.3. Дулааны эрчим хүчний тооцоог тоолуураар хийж байгаа хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээн дээр "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 42 дахь заалтыг үндэслэн дулааны шугамын алдагдлыг 5%-аар нэмж тооцно.

6.4. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад холболт, тохируулгын буруутай үйлдэл, тоолуурыг дур мэдэн таслах, лац ломбо гэмтээсэн болон гадны нөлөөгөөр заалт буруу гарсан бол тоолуурын заалтыг хэрэгсэхгүй болгон төлбөрийг зураг төслөөр тооцсон хүчин чадлыг нь үндэслэн /задгайгаар/ нөхөн тооцно.

6.5. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад эвдэрсэн, тоолуурын тэжээлийн доголдол гарсан нь хэрэглэгчээс шалтгаалаагүй болохыг хэмжүүрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоосон тохиолдолд усны тоолуураар тооцдог бол өмнөх 3 сарын дунджаар, дулааны тоолуураар тооцдог бол халаалтын улиралд /тухайн хэрэглэгчийн дулааны ачаалалд өөрчлөлт ороогүй бол/ өмнөх оны тухайн сарын дулааны хэмжээг гадна агаарын температураас хамааруулан, халаалтын бус улиралд тухайн улирлын хамгийн их хэрэглээгээр тус тус нөхөн тооцно.

6.6. Тоолуурыг баталгаажуулах болон бусад шалтгаанаар салгах бол хангагч, хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийг байлцуулан лац ломбоны бүрэн бүтэн байдал болон бусад зүйлийг шалган акт 2% хувь үйлдэж баталгаажуулна.

6.7 Монгол улсын стандарт хэмжил зүйн журмын дагуу баталгаажилтын хугацаа дууссан усны тоолуурыг төлбөрийн хэрэгсэлд тооцохгүй.

## ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

7.1. Хангагч, Хэрэглэгч нар нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн буруутай этгээдэд Монгол улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актын дагуу хариуцлага тооцно.

7.2. Гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хангагч ба хэрэглэгч тал хамтран шийдвэрлэх ба , тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.3. Хэрэглэгч нь халаалт, халуун, хүйтэн усаар хангах инженерийн шугам сүлжээнд дур мэдэн схем өөрчлөн бусад өмчлөгчдийн болон төвлөрсөн системд хохирол учруулбал Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.4. Хангагч нь хэрэглэгчээс гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

7.5. Хангагч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлөхөөс татгалзана.

7.6. Энэхүү гэрээг жилд нэг удаа дүгнэж, хэрэгжилт болон зарим заалтад өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.7. Хэрэглэгч нь энэхүү гэрээнд заасан төлбөр төлөх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, төлбөр төлөх хугацааг 2 ба түүнээс дээш сараар хэтрүүлсэн тохиолдолд хангагч нь холбогдох хуулийн дагуу Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл оруулах бөгөөд мэдээлэл оруулсан, эсхүл мэдээлэл харсантай холбоотой үүсэх аливаа асуудлыг хангагч хариуцахгүй.

## НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл тухайлбал газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэтийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн

5

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ХАНГАГЧ:**
**"Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ**

**Хууль гэрээний мэргэжилтэн.............**
**Б.Нямжаргал**
**Гарын үсэг: ............................................**
**Утас: 91917488**

**ХЭРЭГЛЭГЧ:**
**Чинзасагт ХХК**
**Эрдэнэцог овогтой Батмөнх**
**Гарын үсэг: ............................................**
**Утас: 91692039, 91910260**
**Шаардлагатай үед холбоо барих утас:**
**96642222, 88070842**
**И-мэйл: chinzasagtlaw@gmail.com**

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС

**ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

Энэхүү гэрээг 20.... оны дугаар .... сарын .... өдрийг хүртэл .... жилийн хугацаатай сунгав.

Сунгалт хийсэн:
Хангагчийг төлөөлж: ............................................ Хэрэглэгчийг төлөөлж: ............................................

| № | Усны тоолуурын гэрчилгээний дугаар | Лацны дугаар | Баталгаажуулсан огноо | Баталгаажуулах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |

**ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

Энэхүү гэрээг 20.... оны дугаар .... сарын .... өдрийг хүртэл .... жилийн хугацаатай сунгав.

Сунгалт хийсэн:
Хангагчийг төлөөлж: ............................................ Хэрэглэгчийг төлөөлж: ............................................

| № | Усны тоолуурын гэрчилгээний дугаар | Лацны дугаар | Баталгаажуулсан огноо | Баталгаажуулах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |

**ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

Энэхүү гэрээг 20.... оны дугаар .... сарын .... өдрийг хүртэл .... жилийн хугацаатай сунгав.

Сунгалт хийсэн:
Хангагчийг төлөөлж: ............................................ Хэрэглэгчийг төлөөлж: ............................................

| № | Усны тоолуурын гэрчилгээний дугаар | Лацны дугаар | Баталгаажуулсан огноо | Баталгаажуулах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |

7

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төг/сар | 41-81 м2 талбайтай | 5,000 | - | |
| | | төг/сар | 81 м2-с дээш талбайтай | 10,000 | - | |
| 3 | Нийтийн эзэмшлийн дулаан /Орон сууцны халаалт, оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна/ | Төг/м² 800 | | | | |
| ЦЭВЭР БОХИР УС | | | | | | |
| 4 | Цэвэр ус | төг/литр | | 1,0 | 3 20 | Хот суурины, ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тухайн үеийн батлагдсан үнэ тариф |
| 5 | Бохир ус | төг/литр | | 0,6 | 2,56 | |
| 6 | Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамж | 15<br>20<br>25<br>32<br>40<br>50<br>65<br>80<br>100<br>150<br>400* | | 1 800 | 3 600<br>4 960<br>7 600<br>11 200<br>16 720<br>25 680<br>32 640<br>44 240<br>65 600<br>104 400<br>384 000 | |

## ЗӨВЛӨМЖ

1. Цэвэр усны нөөц хязгаарлагдмал байдгийг санаж, ус хэмнэлттэй хэрэглэдэг холигч, крант, суултуур хэрэглэх зэргээр усыг үргүй зарцуулахаас сэргийлэх нь эдийн засгийн ач холбогдолтой. Усны тоолуур хэрэглэх нь үр ашигтай төдийгүй хэрэглэсэн усны төлбөрөө шударгаар төлөх нөхцөл болдог.
2. Сантехникийн тоноглолыг зөв ашиглаж сурах нь тоноглолын эвдрэлээс сэргийлж өрхийн орлогыг хэмнэдэг.
3. Крантыг хаахдаа хэт чангалбал амархан эвдэрдэг. Халуун, хүйтэн усны крантыг зөөлөн эргүүлж хааж, нээснээр товх резиний эдэлгээ уртасдаг.
4. Цахилгаан, сантехникийн төхөөрөмжид гэмтэл гарсан үед орон сууцны байгууллагын ээлжийн инженерт нэн даруй мэдэгдэж хэвийн ажиллагаатай болгох нь цаашид гарч болзошгүй эрсдэл, аюулаас сэргийлэх.
5. Цахилгааны нэг розеткад хоёроос дээш хүчин чадал ихтэй цахилгаан хэрэгслийг залгаснаас ачаалал ихдэж галын аюул гарах магадлалтай байдаг.
6. Гэнэтийн хүчдэл ихсэж цахилгаан хэрэгсэл шатахаас болгоомжлох найдвартай арга нь гал хамгаалагч автоматыг стандартын дагуу суурилуулах байдаг.
7. Олон хоногоор эзэнгүй байх үед холбоо барих утасны дугаарыг бүртгүүлэх, эзэмшигч өөрчлөгдсөн үед хангагчид мэдэгдэх.

## САНАМЖ

1. Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлж буй засварчны үнэмлэхийг заавал шалгах бөгөөд хангагч байгууллагын ажилтанд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрт хэрэглэгчээс бэлэн мөнгө авахыг хатуу хориглодог.

9

**БАТЛАВ**
НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
БОРХОЙН БАЯН БҮРД ОНӨ ААТҮГ-ЫН ДАРГА Г.ЭНХБАТ

2025 оны ... дугаар сарын ... өдөр

**БАТЛАВ**
ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЧИН ЗАСАГТ ХХК ЗАХИРАЛ Э.БАТМӨНХ

2025 оны ... дугаар сарын ... өдөр

## МОД СУУЛГАЦ ХУДАЛДАХ , ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2025 оны ... дугаар сарын ... № Замын-Үүд сум

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль бусад хууль тогтоомжийн дагуу нэг талаас **Борхойн баян бүрд Орон нутгийн өмчит ААТҮГ-ыг төлөөлж оны инженер Хайнзангийн Билэгт** /Цаашид **"Худалдагч"** гэх/ нөгөө талаас **Чинзасагт ХХК** /цаашид **"Худалдан авагч"** гэх/-ийг төлөөлж ........Гүйцэтгэх захирал Э.Батмөнх........нары н хооронд /Цаашид хамтад нь **"Талууд"** гэх/ дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцож байгуулав.

### НЭГ. ЗОРИЛГО

1.1. Монгол Улсын Борхойн Баян Бүрд Орон нутгийн өмчит ААТҮГ, Чинзасагт ХХК-ны хооронд байгуулсан тарьц, суулгац худалдах, худалдан авах явцыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1 Талууд энэхүү гэрээний үндэслэл болгосон баримт бичгийн үзэл санааг хэрэгжүүлж худалдах зарчимд нийцсэн, холбогдох хууль тогтоомжийг баримтлан хамтын ажиллагаагаа боловсронгуй болгон харилцан ашигтай ажиллаж, чанарын шаардлага хангасан буюу говьд ургах боломжтой дасан зохицсон мод буюу хайлаас, улаан сухай, улиас модыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2 Талууд гэрээгээр тохиролцсон үнэ, хэмжээ, нөхцөлөөр нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

3.1 Энэхүү гэрээгээр нийлүүлэгдэх худалдан авалт хийгдэхээс өмнөх үнийн саналыг харилцан тохиролцсоны дагуу Худалдагч нөгөө талаас Худалдан авагчийн хооронд дараах материалын үнэ, худалдах, худалдан авах нөхцлийг хэлэлцэн тохиролцож байгуулав.

Хүснэгт №1. Мод, сөөгний тарьц, суулгацын үнэ

| № | Модны төрөл | Тоо, ширхэг | Нэгж үнэ /төг/ нөатгүй | Нийт үнэ /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Улаан сухай | 100 | 5,500 | 550,000 |
| 2 | Улиас | 100 | 35,000 | 3,500,000 |
| Дүн | | | | 4,050,000 |
| 3 | Ажлын хөлс | 1 | 450,000 | 450,000 |
| **Нийт дүн** | | | | **4,500,000** |

3.2 Энэхүү гэрээнд тусгагдсан худалдан авалтын нийт үнийн дүн **4,500,000 (дөрвөн сая таван зуу мянга) төгрөг** байна.

## ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ НӨХЦӨЛ

4.1. Гэрээний үнийн дүн нийт 4,500,000 (дөрвөн сая таван зуу мянга) төгрөгийн санхүүжилт олгохоор талууд харилцан тохиролцсон болно.

4.2 Бүтээгдэхүүн хүлээлгэн өгөхдөө хоёр талын эрх бүхий хүмүүс орлого зарлагын баримт бүрдүүлнэ.

4.3 Төлбөрийг нийлүүлэгч Борхойн Баян Бүрд Орон нутгийн өмчит ААТҮГ РД8275092 Хаан банкны 5374626707 тоот дансанд шилжүүлнэ.

## ТАВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Худалдагч тал нь Шилмүүст төрлийн модны суулгац Техникийн шаардлага: MNS 6139:2010, Навчит модны суулгац, Техникийн шаардлага: MNS 6141:2010, Мод, сөөгний тарьц: Техникийн шаардлага, MNS 6140:2010 стандартын шаардлага хангасан тарьц, суулгацыг худалдан авагч талд нийлүүлэх үүрэгтэй.

5.2 Дараах төрлийн мод, сөөг байна.

Хүснэгт №2. Модны төрөл тоо, ширхэг

| Модны төрөл | Тоо ширхэг | Техникийн шаардлага |
|---|---|---|
| Улаан сухай | 100 | Суулгац нь өвчин, хортонд нэрвэгдээгүй. Үндэсний хөгжил сайтай. Өндөр 50 см-ээс дээш өндөр зөв ургалттай. Замын-Үүд хөрсөнд дасан зохицсон. Ургах чадвар сайтай. Үндэсний систем сайн. |
| Улиас | 100 | Суулгац нь өвчин, хортонд нэрвэгдээгүй. Үндэсний хөгжил сайтай. Өндөр 1м-ээс дээш өндөр зөв ургалттай. Замын-Үүд хөрсөнд дасан зохицсон. Ургах чадвар сайтай. Үндэсний систем сайн. |
| Нийт | 200 | |

5.2.1. Тухайн тарьц, суулгац нь тоо, чанарын шаардлага хангасан, хугарч гэмтээгүй, үндэсний систем хатаагүй бүрэн бүтэн байна.

5.2.2. Худалдагч тал гэрээ захиалга өгсөнөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүй тарьц, суулгацыг худалдан авагчид шилжүүлнэ.

5.2.3. Барааг авах үед тээвэрлэхэд зориулан бэлтгэсэн байна. /зөөвөрлөлт даах/

5.2.4. Үндэсний систем хатаж гэмтэхээс сэргийлж боож багласан байна.

5.2.5. Төлбөрийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.

## ЗУРГАА. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Худалдагчаас тарьц, суулгацыг шилжүүлж авах хугацаар урьдчилан мэдэгдснээс хойш 7 хоногийн дотор хүлээн авна.

6.2. Худалдаж авсан тарьц, суулгацыг шалгах болон ашиглах явцад илэрсэн зөрчлийг худалдагчдад мэдэгдэж арилгуулах.

6.3. Худалдаж авсан тарьц, суулгацыг хүлээн авсанаас хойшхи модны гэмтлийг нийлүүлэгч тал нөхөн төлөхгүй.

## ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

7.1. Худалдагчийн буруугаас гэмтэж хатсан, хугарсан доголдолтой тарьц суулгац шилжүүлсэн бол уг доголдлыг арилгах.

7.2. Худалдагчийн буруугаас тарьц, суулгацыг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд шилжүүлээгүй тарьц, суулгацын үнийн дүнгийн 1-2 хувиар тогтоон худалдан авагч талд торгууль төлнө.

7.3. Худалдагдсан тарьц, суулгацын үнэ тухайн үеийн ижил чанар, төрлийн хөрөнгийн зах зээлийн үнээс илт зөрөөтэй бол талууд тарьц, суулгацын үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.

7.4. Энэ гэрээний нөхцлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал батална.
7.5. Худалдагч нь гэрээний нөхцлийн дагуу чанар стандартад нийцсэн материалыг заасан тоо хэмжээгээр Худалдан авагчид хүлээлгэн өгнө. Энэхүү гэрээний дагуу төлбөр хийгдээгүй тохиолдолд зогсооно.
7.6. Худалдан авагч Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлнө.
7.7. Энэхүү гэрээний 4.1, 4.2-т заасны дагуу төлбөр хийгдээгүй нөхцөлд үүнээс гарах хохирлыг худалдагч тал хариуцахгүй.

## НАЙМ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1. Хэрэв аль нэг тал энэхүү гэрээний дагуу үүргээ, нөхцөлийг хэсэгчлэн болон бүрэн гүйцэтгэж чадахгүйд хүрвэл нөгөө талдаа энэ тухай урьдчилан мэдэгдэж тодорхой арга хэмжээ авна.
8.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн маргаан гарвал найрсгаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Арбитраар маргааныг эцэслэн шийдвэрлүүлнэ.

## ЕС. ГЭРЭЭ ҮЙЛЧИЛЭХ ХУГАЦАА

9.1. Гэрээний үйлчлэх хугацаа 2025 оны 10 сарын 13-ны өдрөөс 2025 оны 10 сарын 17-ны өдөр хүртэл байна.
9.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр тохиролцож сунгаж болно.
9.3. Гэрээний үйлчлэх хугацааг дараах тохиолдолд зогсоож болно.
   9.3.1. талуудын зөвшилцсөнөөр;
   9.3.2. монгол улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр;
   9.3.3. давташгүй хүчин зүйлийн үйлчлэлээр.

## АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1. Давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, дайн, хорио цээр гэх мэт)-ийн нөхцөл байдлыг шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
10.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

## АРВАН НЭГ. БУСАД НӨХЦӨЛ

11.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болж худалдан авалтын төлбөр бүрэн
11.2 Гэрээнд заасан нөхцөлүүдийг хоёр тал харилцан биелүүлнэ.
11.3 Гэрээнд оруулах аливаа өөрчлөлтийг бичгээр үйлдэж хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээг Монгол хэл дээр тус бүр 2 хувь үйлдэв.

## АРВАН ХОЁР. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

12.1. Аль нэг тал компанийн бизнес төлөвлөгөө болон энэ гэрээний дагуу мэдэх болсон бусад талуудын бизнесийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 7 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ

## АРВАН ГУРАВ. ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

13.1 Талууд гэрээ байгуулах өдрийн байдлаар дараах албан ёсны хаягт байрлаж байгаа бөгөөд хаяг өөрчлөгдсөн тохиолдолд нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
13.1.1

| Худалдагч тал: | Худалдан авагч тал: |
|---|---|
| Хаяг: Дорноговь аймаг Замын-Үүд сум Сүлд баг ЗДТГ 2-р байр ойн инженер Х.Билэгт Утас: 95904000 | Дорноговь аймаг,Замын-Үүд сум, 3-р баг, Төмөр замын баруун талд Утас -91692034 |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
БОРХОЙН БАЯН БҮРД ОРОН НУТГИЙН ЭМЧИТ ААТҮГАЗРЫН ОЙН ИНЖЕНЕР
Х.БИЛЭГТ

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЧИН ЗАСАГТ ХХК-НЫ ЗАХИРАЛ
Э.БАТМӨНХ